Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# УЛСЫН СҮЛЖЭЭ, УУР АМЬСГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин /эхний хагас жил/ | Хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| НЭГ.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт | | | | | | | |
| "УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ САЛБАРЫН 2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ"-ний Зорилт-1: "Ус цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний хэвийн үйл ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, техник технологийн шинэчлэл хийх" | | | | | | | |
| 1 | **Гүйцэтгэлийн зорилт 1**: Ус цаг уур, байгаль орчны хяналт, шинжилгээний улсын сүлжээг автоматжуулах | | Автоматжуулсан хувь | 44,3 | 47,8 | 2025 оны эхний хагас жилд ус судлалын 4 харуул, орчны шинжилгээний 12 салбарт автомат төхөөрөмж шинээр суурилуулсанаар нийт ус, цаг уур, орчны шинжилгээний улсын сулжээний 47.2 хувь автомат тоног төхөөрөмжөөр хэмжил хийх боломж бүрдсэн. | 90,9 |
| 2 | **Арга хэмжээ-1.1. А**эрологийн шинжилгээний өртөө Өвөрхангай, Говь-Алтай аймагт байгуулах | Гадаад тусламж | Шинээр хөөргөлт хийж эхэлсэн станцын тоо | 0 | Бэлтгэл ажил хангасан байна. | БНХАУ-ын Ц аг уурын газарын 4 мэргэжилтэн 05 дугаарын 12-19-ны хугацаанд Өмнөговь, Говь-алтай аймгуудад ажиллаж, аэрологийн шинэ систем суурилуулах газрын байрлалыг тодорхойлж, уулзалт хийсэн. 2 тал харилцан тохиролцож суурилуулах ажлын бэлтгэлийг бүрэн хангасан. Тус системын тоног төхөөрөмж 7 дугаар сард тээвэрлэхээр тохиролцсон. БНСУ-ын Цаг уурын газар болон хүрээлэн, төслийн гүйцэтгэгч компанийн төлөөлөл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 05 дугаар сарын 12-14-нд ЦУОШГ болон Өвөрхангай аймагт ажилласан. Тус бүрэлдэхүүнтэй болон гүйцэтгэгч компанийн төлөөлөлтэй олон удаагийн уулзалтыг зохион байгуулж, санал солилцож, шаардлага арга хэмжээг авч ажилласан. Өвөрхангай аймагт аэролгийн хөөргөлтийн шинэ систем болон устөрөгч гарган авах төхөөрөмжийг суурилуулж сургалт зохион байгуулсан. Сургалтад Улаанбаатар болон Увс, Хөвсгөл, Өвөрхангай аймгийн төлөөлөлийг оролцуулах ажлыг зохион байгуулсан. | |
| 3 | **Арга хэмжээ-1.2.** Аэрологийн шинжилгээний өртөөний газрын станцыг шинэчлэх | Гадаад туслам ж | Шинэчилсэн станцын тоо | 0 | 3 | Увс, Хөвсгөл, Улаанбаатар хот болон бусад аэрологийн өртөөнд /нийт 5 ш/ ашиглаж буй SR10 газрын станцыг SR20 газрын станцаар үнэ төлбөргүй солих гэрээг Франц улсын Модем компанитай байгуулсан. Гэрээний дагуу тус компаниас 5 иж бүрдэл SR20 станцыг 04 сарын 10-нд ирүүлснийг хүлээн авч Улаанбаатар болон Увс, Хөвсгөл аймгийн УЦУОШТ-д хүргүүлж, холбогдох тохиргоог хийж, радиозондийн системыг шинэчлэн хөөргөлтийг эхэлсэн. | 100 |
| 4 | **Арга хэмжээ-1.3. Цаг уурын автомат станцын сүлжээг өргөтгөх** | Улсын төсөв 1 тэрбум | Цаг уурын автомат станцын тоо | 217 | Бэлтгэл ажлыг хангах | Цаг уурын автомат станц 10 ширхэгийг худалдан 1.0 тэрбум төгрөгийн зардлыг БОУАӨ-ийн Сайдын багцаас шийдвэрлүүлж, техникийн тодорхойлолт болон холбогдох материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Тус газраас 02 дугаар сарын 17-ны өдөр тендер зарлан, 04 сарын 25-ний өдөр нээлтийг хийж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах шатанд байгаа бөгөөд бэлтгэл ажлыг бүрэн хангасан. | 100 /70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | **Арга хэмжээ-1.4.** Ус судлалын 17 автомат станцыг шуурхай ажиллагаанд оруулах | Улсын төсөв | Автомат түвшин хэмжигч багаж суурилуулсан харуулын тоо | 0 | Бэлтгэл ажлыг хангах | Шинээр худалдан авсан ус судлалын 17 автомат станцын хуваарийг 10 төвийн 17 гүүрэн байгууламжид суурилуулахаар батлуулж, бэлтгэл ажлыг хангасан. Улаанбаатар хотын УЦУОШТ-ийн болон Хүрээлэнгийн инженерүүд Зайсан, Сэлбэ, Тэрэлж голын гүүрүүдэд суурилуулахаар ажиллаж байна. | 100 / 70% |
| 6 | **Арга хэмжээ-1.5.** Ус судлалын автомат станцыг өргөтгөх | Улсын төсөв | Цаг уурын автомат станцын тоо | 0 | - | Ус судлалын автомат станц 10 ширхэгийг худалдан 1.0 тэрбум төгрөгийн зардлыг БОУАӨ-ийн Сайдын багцаас шийдвэрлүүлж, техникийн тодорхойлолт болон холбогдох материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Тус газраас 02 дугаар сарын 17-ны өдөр тендер зарлан, 04 сарын 25-ний өдөр нээлтийг хийж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах шатанд байгаа бөгөөд бэлтгэл ажлыг бүрэн хангасан | 100 / 70% |
| 7 | **Арга хэмжээ-1.6. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шинэ техник, технологи нэвтрүүлэх** | Улсын төсөв | Сэрүүний улиралд цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулах бэлэн байдлыг хангасан байдал /хувиар/ | 0 | 50 | Сэрүүний улиралд ашиглах боломжтой цаг агаарт зориудаар нөлөөлөх пуужин, харвах төхөөрөмжийн стехникийн боломж, үнийн судалгааг хийж, 200 сая төгрөгөөр 40 ширхэг пуужин, харвах төхөөрөмжийн хамтаар авах боломжтой тухай саналыг БОУАӨ-ийн Сайдад хүргүүлэн улмаар Засгийн хуралдаанд танилцуулагдсан. | 100 / 70% |
| 8 | **Арга хэмжээ-1.7** Ус судлалын улсын сүлжээний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Нэн шаардлагатай хэмжих хэрэгслээр хангасан байдал | - | Шаардлагатай хэмжих хэрэгслийн судалгаа гаргах | Ус судлалын 155 харуулд шаардлагатай хэмжих хэрэгслийн судалгааг гарган, нэн шаардлагатай байдлаар эрэмбэлж, Газрын даргад танилцуулан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан. | 100 |
| 9 | **Арга хэмжээ-1.8** Ус, цаг уур орчны шинжилгээний ажлын зааврыг шинэчлэн, ус судлалын харуулуудыг | Улсын төсөв | Нэмэлт өөрчлөлт оруулсан байх | - | | Дүгнэх хугацаа болоогүй | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллээр ханган ажиллах | | | | | | |
| 10 | **Арга хэмжээ-1.9** Богд бороо экспедицыг шаардлагатай үед ажлуулах | Улсын төсөв | Экспедицийн үйл ажиллагаа явуулсан байна /тоо/ | - | 3 хүртэл | Улаанбаатар хотын хуурайшил ихссэнтэй холбогдуулан Богд бороо экспедиц 5-р сарын 12 болон 15-ны өдрүүдэд 2 удаа Төв аймгийн Алтанбулаг, Жаргалант, Батсумбэр сумдын нутгаар үйл ажиллагаа явуулсан. | 100 |
| 11 | **Арга хэмжээ-1.10** Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны чиглэлээр экспедицүүдийг зөвлөгөө, зааварчилгаагаар хангаж, аюулгүй ажиллуулсан байна. | - | Аюулгүй ажилласан экспедицийн ажилласан тоо | 45 | 45 | ЦУОШГ-ын даргын тушаалаар 2025 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг эхлүүлж III сард 13, IV сард 20, V сард 66 удаа үйл ажиллагааг аюул осолгүй явуулж, нийт 289 пуужин зарцуулсан. Бүх экпедицүүдийн үйл ажиллагааны акт, тайланг хүлээн авч нэгтгэж, заавар зөвлөмжөөр хангаж ажиллаа. | 100 |
| 12 | **Арга хэмжээ-1.11** ЦУОШГ-ын Гамшгийн үед ажиллах төлөвлөгөөнд шинэчлэл хийх | - | Шинэчлэл хийгдсэн хувь | | | ОБЕГ-ын ахлах мэргэжилтэн дэд хурандаа Б.Алтан-Очирын өгсөн чиглэлийн дагуу харьяа байгууллагуудын судалгаа болон албан хаагчдын судалгааг нэгтгэн авч ЦУОШГ-ын “Онцгой байдлын төлөвлөгөөн”-нд оруулан, хянуулахаар дахин хүргүүлсэн. БОУАӨЯамны сайдын “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” тушаалын дагуу хүн хүч, техник хэрэгслийн мэдээллийг нэгтгэн БОУАӨЯ-ны Өргөдөл гомдол жендэр гамшиг дайчилгаа хариуцсан ахлах зохион байгуулагч С.Батзоригт хүргүүлсэн. | 50 |
| 13 | **Арга хэмжээ-1.12** Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар, журмыг шинэчлэх | - | Батлагдсан төлөвлөгөөний тоо | | | Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн заавар болон Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажилтан, албан хаагчдын мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах ЦУОШГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 18 ны өдрийн А/314 | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тоот тушаал дагуу ажлын хэсгийн гишүүдэд төслийг цахим хэлбэрээр хүргүүлсэн. УЦУОШ-ны Салбарын нийт ХАБ хариуцсан ажилтнуудад цахим хэлбэрээр тараан санал авсан. Ирүүлсэн саналыг дүрмийн төсөлд тусгасан. | |
| 14 | **Гүйцэтгэлийн зорилт 2**: Орчны чанарын хяналт шинжилгээ, багаж тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах | Улсын төсөв, гадаад зээл тусламж | Үйл ажиллагааны хэрэгжилт /хувиар/ | 0 | 100 | 1.21 аймагт агаарын чанарын автомат станц суурилуулах ажил амжилттай хэрэгжиж байна.<br>2. Орон нутгийн лабораториудад шаардлагатай багажийг хэрэгслийн судлагааг гаргаж, нэн шаардлагтай 6 төрлийн 32 багаж, хэрэгслийг 100 сая төгрөгөөр худалдан авах саналыг худалдан авах авах төлөвлөгөөнд тусгуулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна. | 96,6 / 70%. |
| 15 | Арга хэмжээ 2.1: Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн шинэ барилгын ажлыг эхлүүлэх, дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангах | 14,8 сая $ | Үйл ажиллагааны хэрэгжилт, % | Загвар зураг батлагдсан. | - | “Байгаль орчны төв лабораторийн чадавхыг сайжруулах төсөл”-ийн Удирдах хорооны хурлыг 3 удаа зохион байгуулж ажилласан. Төслийн хугацаа 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр дуусаж байгаатай холбогдуулан Сангийн яам, БНСУ-ын Эксим банканд хүсэлт хүргүүлэн төслийн хугацааг 24 сараар сунгуулсан. Шинээр баригдах лабораторийн барилгын зураг төсвийг эцэслэн боловсруулж, Барилгын хөгжлийн төвөөр 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр батлуулсан.<br>“Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн шинэ барилгын цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, холбооны гадна шугам сүлжээний зураг, төсвийн хэмжээ тооцох ажил”-ын тендер шалгаруулалтыг 2025 оны 04 сарын 16-ны өдөр нээлттэй зарлаад байна. | 90 / 70%. |
| 16 | Арга хэмжээ 2.2: Агаарын чанарын автомат станцыг төв, орон нутагт суурилуулах | 8,9 сая ам $, БТ | Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлийн хувь | суурь судалгаа хийгдэж, 1ш Улаанбаата | эхний 7 аймгийн багаж, тоног | Суурь судалгаг хийж, АЧС-ийн суурийг бэлтгэх, АЧС-ын багаж, тоног төхөөрөмжийг Гааль, нөат-аас чөлөөлөхөд шаардлагатай баримт бичгийг гаргуулж, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | р хотод суурилуулсан | төхөөрөмж гаалиас авах | Архангай, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Увс, Орхон, Дархан-Уул аймагт АЧС-ыг суурилуулж, 2 өдрийн сургалт хийж, одоо туршилтын байдлаар ажиллаж байна. Дараагийн 7 аймагт суурилуулах багаж, тоног төхөөрөмжийг гааль НӨАТ-аас чөлөөлөх зөвшөөрлийг СЯ-аас гаргуулан, ачааг агуулахад хийсэн. | |
| 17 | Арга хэмжээ 2.3: Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Улаанбаатар хотод хүнд металл тодорхойлох ICP-OES, микродолгионы сорьц задлагч багаж тоног төхөөрөмж худалдан авах | 928 сая ₮, УТ | Үйл ажиллагааны хэрэгжилт, % | - | үнэлгээний хороо байгуулж, тендер зарласан байна | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд БОХЗТЛ-д хөрсөн дэх хүнд металл тодорхойлох ICP/OES багаж авах тендерийг зарласан. | 100 / 70 |
| 18 | **Гүйцэтгэлийн зорилт 3**. Төвийн бүсийн мезомаштабын ус, цаг уурын үзэгдлийн хэт богино хугацааны прогнозын системд шаардлагатай бүх төрлийн ажиглалт, хяналт мониторингийн мэдээ, мэдээллийн нэгдсэн систем бий болгох | Улсын төсөв | Системийн боловсруулалтын явц | - | Загварт оролтын мэдээ хэлбэрээр бүрэн бэлтгэсэн байна. | Цаг уурын сүлжээнд ажиллаж буй бүх төрлийн автомат станцын шингэн тунадас болон бусад цаг уурын үндсэн үзүүлэлтүүдийг 1 минут тутамд төв серверт дулааны улиралыг дуустлах хугацаанд хүлээн авч, мэдээллийн сан үүсгэж, загварт ашиглах бэтгэлийг хангаж байна. | 100 |
| 19 | Арга хэмжээ 3.1Улсын сүлжээний Багаж тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах | Улсын төсөв | Шалгалт тохируулга баталгаажуулалтын хувь | 90 хувь | - | http://192.168.100.13/currentweather/HMDTS/main_aws_list_admin.asp системийн программд ЦУАС-д хийгдэж байгаа өдөр тутмын засвар үйлчилгээний ажлыг бүртгэж, хяналт тавьж, чиглэл, зөвлөмж өгч ажилласан. Багаж хэмжих хэрэгслийн засвар үйлчилгээг 01 дүгээр сард Увс, Ховд, Завхан, Говь-Алтай Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Орхон, Сэлэнгэ, Говьсүмбэр Өмнөговь, Дорноговь Дундговь аймгийн 63 цаг уурын станцад засвар үйлчилгээ хийсэн. 02 дугаар сард 58ш цаг уурын станц, 03 дугаар сард 48ш, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 04 дүгээр сард 55ш, 05 дугаар сард 28ш станцад засвар үйлчилгээг хийснийг бүртгэж баталгаажуулсан байна. | |
| 20 | **Арга хэмжээ 3.2** Химийн бодисын зөвшөөрөл авах | Улсын төсөв | Зөвшөөрөл авсан лабораторийн тоо | - | 10 | Химийн бодисын зөвшөөрөл авах ажлын хүрээнд Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт, химийн бодисын эрсдэлийн үнэлгээ хийх заавар, загвар тайланг хүргүүлж дараах 12 аймаг Ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргуулан Химийн бодис ашиглах зөвшөөрөл авсан. Үүнд: ДА, ХО, ДГ, ДО, УВ, БӨ, ӨВ, ГА, ОР, СҮ, СЭ, ЗА, | 100 |
| 21 | **Гүйцэтгэлийн зорилт 4.** Төвийн бүсийн мезомасштабын ус, цаг уурын үзэгдлийн хэт богино хугацааны прогнозын систем боловсруулах | Улсын төсөв | Хэрэгжилтийн явц | - | Систем боловсруулахад оролцсон байна. | Хэт богино хугацааны загварын оролтын мэдээгээр анхны нөхцөлийг ассимляци хийх хиймэл дагуулын босоо профиль, радар болон газрын мэдээ бэлтгэх ажилд радар мэдээллийн бэлэн байдлыг хангах чиглэлээр оролцсон. | 85 |
| 22 | **Арга хэмжээ-4.1** Мэдээлэл солилцоо, дамжуулалтын чанарыг сайжруулах, дотоод сүлжээний тоног төхөөрөмжийг шинэчлэх | Улсын төсөв | Хэрэгжилтийн явц | | Цаг уурын нэгдсэн сүлжээний роутерийн тохиргоог хийх | Цаг уурын нэгдсэн сүлжээний роутерийн тохиргоог хийж, сүлжээнд тавихад бэлдсэн.<br>Шинэ суперкомпьютер суурилуулж, алсын зайнаас хандаж систем програм хангамж суулгах ажлын хүрээнд шинэ роутерийг сүлжээнд тавьж бэлдсэн. | 80 |
| 23 | **Арга хэмжээ-4.2** Ус, цаг уур, орчны өртөө, харуулын мета өгөгдлийн сан байгуулах | Улсын төсөв | Ажлын явц, гүйцэтгэл, хувь | 0 | 50 | Ус, цаг уурын өртөө, харуулуудын түүхийн дэвтэрт бүртгэгдсэн мэдээллийг баяжуулж, бүх суурь мэдээллийг төвүүдээс шинэчлэн гаргуулж байна. ДЦУБ-ын OSCAR/Surface платформ, стандарт/ No.1192/-ыг орчуулж эхэлсэн, Суурь түвшний 14 жагсаалтыг гарсан. ДЦУБ-ын мэргэжилтэн мисс.Ран-тай цахим шуудан болон цахим уулзалт хийж зөвлөлгөө авч ажиллаа. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 24 | **Арга хэмжээ 4.3** ХАА-н мэдээллээр нийтийн хэрэгцээнд нийцүүлж үйлчилгээг сайжруулах | Улсын төсөв | Сайтын хандалтын тоо, Хэрэглэгчийн сэтгэл ханамж нэмэгдсэн эсэх | 0 | 100 | Дүгнэх хугацаа болоогүй | |
| 25 | **Арга хэмжээ 4.4** ДЦУБ-ын ажиглалтын сүлжээнд цаг уурын ажиглалтын бүх өртөөний мета өгөгдлийг оруулж шинэчлэх | Улсын төсөв | 138 өртөөний мэдээ орсон эсэх | 72 өртөө | 138 | Мета өгөгдлийн сан байгуулах тандан судалгааны хүрээнд ДЦУБ болон бусад байгууллагын /статистикийн газар, онцгой байдал, opendata.mn, ДЦУБ-ын OSCAR/Surface платформ/ мэдээллийн сангийн бүтэц, агууллагыг судалаж өртөө, харуулын ерөнхий мета дата жагсаалтын драфт гаргасан. ДЦУБ-ын https://oscar.wmo.int/surface/#/ Платформд заасан дагуу уур амьсгалын бүсийг Коппены ангилалаар тодорхойлох ёстой байдаг. Иймд Коппены ангилалыг орчуулж орон нутгийн мэдээлэл үйлчилгээ хариуцсан инженерүүдэд ангилалын зааварчилгаа, жишээг гаргаж FTP-гээр хүргүүлсэн. | 80 |
| 26 | **Арга хэмжээ 4.5** MNS ISO IEC 17025:2018 стандартын дагуу хэмжилзүйн лабораторийг итгэмжлэлд хамруулах | Улсын төсөв | Итгэмжлэлд хамрагдсан лабораторийн тоо | 0 | - | Хэжилзүйн лабораториос MNS ISO IEC 17025:2018 стандартын шаардлагын дагуу холбогдох материалыг бүрдүүлэн Итгэмжлэлийн үндэсний төвд хүргүүлсэн бөгөөд урьдчилсан баримт бичгийн шалгалтыг тус хорооноос хийгээд байна. | 80 /70%. |
| 27 | **Арга хэмжээ 4.6**: MNS ISO IEC 17025:2018 стандартын дагуу орон нутгийн БОШЛ-уудыг итгэмжлэлд хамруулах, итгэмжлэл сунгуулах | Улсын төсөв | Итгэмжлэлд хамрагдсан лабораторийн тоо | 16 | 17 | Итгэмжлэлийн Үндэсний төвөөс нэгдсэн журмаар итгэмжлэлд хамруулах бодлого барьж байгаа учраас орон нутгийн лабораториудад төвөөс стандартын шаардлага хангасан эсэхэд аудит болон хяналт хийх шаардлагатай байгаа. | 50 |
| 28 | **Арга хэмжээ 4.6**: ISO9001 чанарын межементийийн тогтолцоо нэвтрүүлэх ажилд оролцох | Улсын төсөв | Ажлын хэсгийн үүрэг даалгаврын биелэлт | - | 100 | Ажлын хэсэгт хэлтсийн мэргэжилтэнүүд орж ажиллан, ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгавар бүрэн биелүүлж, холбогдох сургалт, уулзалтад бүрэн хамрагдсан. | 100 |
| 29 | Арга хэмжээ 8.18 Цаг уурын суурин радарын мэдээллийг нэгтгэн | Улсын төсөв | Мэдээллийн системийг үйл ажиллагаанд | - | | Морин-уул болон Зүрх уулын радарын мэдээллийг нэгтгэн харах мэдээллийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж харуулах мэдээллийн систем байгуулах | | ашиглаж байх хувь | | | системийн бий болсон туршилт зүгшрүүлэлтийн ажил хийгдэж байгаа. | |
| 30 | Арга хэмжээ 8.20 Гар утасны аппликейшн шинэчлэх | Улсын төсөв | Хэрэгжилтийн явц | - | 1 | Гар утасны аппликейшн хөгжүүлэх үйл явц, технологийн сонголтууд, хөгжүүлэлтийн шат дамжлага, зардлын тооцоо, болон зах зээл дээрх ижил төстэй аппуудын жишээг судлаж байна. | 50 |
| 31 | **Арга хэмжээ 4.10** Газар болон түүний харьяа байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдээ мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй, шуурхай, тасралтгүй хүргэх зорилгоор цахим хуудаснуудын (namem.gov.mn, weather.gov.mn, archive.weather.gov.mn, alarm.weather.gov.mn) үйл ажиллагааг сайжруулж, хэвийн ажиллагааг хангах. | Улсын төсөв | Хэвийн ажилласан хувь | - | 100 | Газрын даргын үүрэг даалгавраар газарт холбоотой мэдээллийн сайтуудыг нэгэн ижил өнгө үзэмж, фонттой болгов. Түймрийн эрсдэлийн зураглалыг 57 станцаар тооцолдог байсныг 138 станц болгон нэмэгдүүлж, мөн 2 хоногийн урьдчилалтай урьдчилсан мэдээ тооцоолж олон нийтэд түгээж эхэлсэн. https://weather.gov.mn/map Урьдчилан мэдээлэх хэлтсийн хүсэлтээр цаг агаарын эрт сэрэмжлүүлэх системийг Хүрээлэнгийн Батчимэг инженертэй хамтар хэвийн болгож, шинэ домэйн буюу alarm.weather.gov.mn гэсэн хаягруу чиглүүлж, шинэ серверт байршуулан ажиллуулж байна.( https://alarm.weather.gov.mn/) Бид цаг уурын автомат станцуудын мэдээллийг 5 сараас эхлэн нэгтгэж(mgl&korean) эхэлсэн бөгөөд үүнийг олон нийтэд түгээх сувгуудын программ хангамжуудын өөрчилж шинэчилсэн. Ард иргэд, аж ахуйн нэгжийн цаг хугацааг хэмнэх, мөн үйлчилгээгээ цахимжуулах зорилгоор цаг агаарын тодорхойлтын хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэдэг болсон. https://archive.weather.gov.mn Тагнуулын ерөнхий газраас өгсөн зөвлөмжийн дагуу Weather.gov.mn болон archive.weather.gov.mn -д нэвтэрч орсон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүх хэрэглэгчийн мэдээллийн log-ийг бичдэг болгов.<br>Мөн орон нутгийн бүх цахим хуудаснуудыг нэгэн ижил болгов.<br>Хүнд мэдрэгдэх температурын томьёог шинэчлэх шаардлагатай болсон тул, прогноз бодит гэх мэт температур орж байгаа хэсгүүдийн программ хангамжид өөрчлөлт хийсэн. | |
| 32 | **Арга хэмжээ 4.11** Цаг уурын албаны урьдчилан мэдээлэх салбарын өдөр бүр гаргаж байгаа хагас хоног болон 5 хоногийн урьдчилсан бичих веб суурьтай программ хангамжийг(http://192.168.100.30:3030/login) сайжруулах, хэвийн ажиллагааг хангах | Улсын төсөв | Хэвийн ажилласан хувь | - | 100 | Тусгай мэдээ бичдэг программ хангамжийг шинээр нэмж хөгжүүлэн ашиглаж эхэлсэн. Энэхүү программ нь 6 цагийн тунадасны мэдээллийг бичдэгээрээ бусдаас ялгаатай. Хэвийн ажиллаж байгаа бөгөөд 05 сарын 25-нд цахилгааны доголдлоос болж унтарч ассан бөгөөд өөрийн биеэр ирж хэвийн болгов.<br>Тухайн системийн хэрэглэгч бүрийн таарцыг график болон хүснэгтээр харуулдаг болгов үүнийг хийснээр хэн нь илүү таарцтай мэдээ бичиж байгааг харах боломжтой болно.<br>УМХ-ийн даргын хүсэлтээр таарц бодох болон харуулах хэсгийг шинэчилж байгаа. | 100 |
| 33 | **Арга хэмжээ 4.12** Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарын дотоод мэдээлэл солилцооны систем шинээр хөгжүүлэх үйлдвэрлэлд нэвтрүүлэх | Улсын төсөв | Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн эсэх | - | 100 | Дотоод мэдээлэл солилцооны системийг хөгжүүлэх ажлыг 05 дугаар эхэлж гүйцэтгэж, эхний хувилбарыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, ашиглаж эхэлсэн. Гадаад болон дотоод гэсэн 2 сүлжээд зэрэг ажиллаж байгаа бөгөөд гадаад сүлжээнд info.weather.gov.mn гэсэн домэйнийг байршуулсан. Мөн энэхүү мэдээллийн системд зориулан архив мэдээллийн сангийн хуучин серверийг форматалж, систем суулган ашиглалтад нэвтрүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 34 | **Арга хэмжээ 4.13** Цаг уурын автомат станцын 1 минут тутмын мэдээллийг архивлах болон шуурхай үйл ажиллагаанд ашиглах программ хангамжийг сайжруулах, хэвийн, тасралтгүй ажиллагааг хангах. | Улсын төсөв | Хэвийн ажилласан хувь | 2024 оны мэдээлэл | 2025 оны мэдээлэл | 2025 оны 6-р сарын байдлаар нийт 170-190 станцын мэдээллийг нэгтгэж эхэлсэн. Энэхүү ажлыг гүйцэтгэхэд дараах ажлуудыг хийсэн. Үүнд:<br>1. Бид Монгол компани хөгжүүлсэн автомат станцын мэдээллийн сангаас өөрийн мэдээллийн сан мэдээллийн хуулж авах программ хангамж боловсруулсан. Энэхүү программ нь тухайн хугацаанаас 2 минутын өмнөх бүх мэдээллийн өөрийн мэдээллийн санд бичдэг<br>2. 5-р сард ITSNOAH компаниас төлөөлөгч ирсэн, тухайн төлөөлөгч нь LAU системтэй холбоотой нууцлалын мэдээллүүдийн бидэнд өгснөөр бид LAU системийн мэдээллийн санг бүрэн удирдах боломжтой болсон бөгөөд LAU системийн мэдээллийн сангаас минут тутам 50 гаруй станцын мэдээллийн шууд авч байна.<br>Нийт 170-190 гаруй станцын мэдээллийн шуурхай үйлчилгээнд ашиглаж эхэлсэн ч шуурхай мэдээллийн бааз нь хэт их ачаалалтай ажилдаг тул, мэдээллийн хувьд хоцрогдол үүсэн тул дээрх мэдээллийг шууд нийтийн үйлчилгээнд буюу weather.gov.mn -д гаргах ажлыг хийсэн. | |
| 35 | **Арга хэмжээ 4.14** Ус, цаг уурын ажиглалт, хэмжилт болон прогнозын мэдээллийг төрийн болон хувийн байгууллагуудтай (жишээлбэл: E-Mongolia, DDISH, Засгийн газрын цахим системүүд гэх мэт) солилцох API системийг хөгжүүлж, түүний хэвийн, | Улсын төсөв | Хэвийн ажилласан хувь | - | 100 | Манай байгууллага нь зарим нэг мэдээллээ төлбөртэй болгож байгууллагуудтай гэрээ байгуулж үйлчилгээ үзүүлэх болсонтой холбогдуулан API-ийг хамгаалттай буюу заавал зөвшөөрөлтэй хэрэглэгчидэд мэдээлэл өгөх болгож шинэчлэл хийсэн.<br>Зөвшөөрөлтэй байгууллагууд болох Монгол айл ХХК, E-mongolia зэрэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тасралтгүй ажиллагааг хангах. | | | | | байгууллагууд хаалттай мэдээллүүдийг авч байна. | |

*Тайлагнасан:* ***Нэгжийн дарга***

УСУАҮХ-ИЙН ДАРГА .................... Д.УЛАМБАЯР

*(огноо)* ..............................

УЛСЫН СҮЛЖЭЭ, УУР АМЬСГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Д.УЛАМБАЯРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР.

Нэгжийн нэр: УЛСЫН СҮЛЖЭЭ, УУР АМЬСГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 92.9 | 65.03 |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | ISO9001:2015 чанарын удирдлагын тогтолцооны чиглэлээр судалж танилцахөөрийн байгуулагад стандарт нэвтрүүлэхэд оролцох | | |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | |
| 2. | Удирдан зохион байгуулах | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | |
| 4. | Манлайлах | |
| 5. | Багаар ажиллах | |
| 6. | Харилцаа | |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | |
| | **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | |

## 4. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | 63 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 15 |

| | | |
|---|---|---|
| | *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 93. |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

ЦУОШГ-ЫН ДАРГА ................................ Э.БАТТУЛГА

2025.06.28............................ (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга:***

УСУАҮХ-ИЙН ДАРГА ................................ Д.УЛАМБАЯР

....................... *(огноо)*